

mongolian

by *sukhbaatar tsegmid*

ph.d., professor (ulaanbaatar – mongolia)

Сэлэм ба үзэг

Үзэг хугарвал, сэлэм рүү гараа сарвайж хэрэггүй.

Зөн билэг

Зөн билэг хүн бүрд буй

Амьдрал түүнээс эхэлж, түүгээр дуусна.

Агуу их хүч чадлаараа өөрийгөө хүрээлүүлж чадсан эрхэм дээд хүн сүүлчийн сургаалаа хайрласан нь:

Би долоон настай байхдаа авьяас билгээ мартан хайхрамжгүй хандаж, хорооллын ядуу хүүхдэд өөрийнхөө дуртай тоглоомоо бэлэглэсэн. Би өөрөө хийсэн тэр юмыг минь чөлөөлж өг.

Би арван долоон настай байхдаа нөхөрлөлийг хайрлан хүндэлж байсан. Тэр хүслийг минь чөлөөлж өг.

Би хорин долоон настай байхдаа номхон хүлцэнгүй биш ч гэсэн хий хоосон зүйл рүү намайг шууд хөтөлж байсан диплом цуглуулахаа больсон. Миний эзэмшсэн тэр мэдлэгийг чөлөөлж өг.

Би гучин долоон настай байхдаа хий хоосон юм үзэгдлийг ухаарсан. Тэр нэр алдрыг минь чөлөөлж өг.

Би дөчин долоон настай байхдаа үнэний үнэнд итгэж байсан. Тэр метафизик үзлийг минь чөлөөлж өг.

Би тавин долоон настай байхдаа энэрэнгүй харьцааны ихэнх нь бялдуучлал гэдгийг ухамсарласан. Миний тэр үзэл бодлыг чөлөөлж өг. Над шиг жаран долоон нас хүрээд, та жинхэнэ найз нөхөдгүй болбол, даяанч шиг амьдарсан ч түүнээс чөлөөлж өг.

Би далан долоон настай байхдаа бичихээ больж, бүх номоо урж, байгалиас тусгаарласан ч үзэл бодлыг минь чөлөөлж өг.

1999

Дарлалаас чөлөөлөх хэсгээс

Сэвшээ салхи

(Цаг хугацаа, орон зайны тухай төсөөлөл)

Орон зайнд ч, цаг хугацаанд ч огт хязгаарлагдахгүй дэлхий ертөнцөөр хийссээр нялх хүүхдийн уушгинд орж зогсдог сэвшээ салхи юм уу даа би. Тэхэд л амьдралын утга учрыг төсөөлнө.

1995

Аялгуу

(Хүний эрх чөлөө эргэж ирсэн тэр газарт)

Хүн хүнээ, ер нь ард түмэн бие биенээ сөнөөн устгаж байгаад, тэнд эрх чөлөө эргэж ирсэн байнам. Дайсагнасан хүмүүсийг эвлэрүүлэх гэсэн суу заль нь бүтэлгүй мөрөөдөл байсан ч тэрхүү хөг аялгуу нь дурсагдсаар. Тэгээд ч оюун ухаан, хүч чадал, аж амьдралын хөг аялгуу хот тосгон, гол горхи, жигүүртэн шувуудаар дамжин байгаль дэлхийд үлдэж байна.

Тийм л дээ, байгаль дэлхий намайг хөглөж байна шүү.

1997

Яруу найраг

(Волга мөрний эрэг амгалан тайван байсан үе)

Нэгэн ард түмний дунд дэлгэрсэн нэргүй шүлэгт өгүүлэх нь:

Хүүминь,

*Намайг энэ ертөнцөөс халих үед
Миний тухай дурсан гуниглах бол
Чи эрч хүчтэй амьдар,
Миний байгаа аглаг нутагт
Чи ч гэсэн очих болно.
Орших ч бай, эс орших ч бай
Тэнд чи надтай учирна.
Хуудас цаас дэлгэн, өдөн үзгээ барьж
Амьдруулахыг эрэл хийнэ.
1997*

Хадан хавцал

(Монголын говьд төрсөн агшин зуурын бодол)
Хэн ч, хэзээ ч ойртож ирээгүй хадан хавцлын өмнө би зогсож байна.
Тэр хаданд хоёр амрагийг сийлсэн нь хүн төрөлхтний түүх, хүсэл
мөрөөдлийн илэрхийлэл мэт.
1995

Сайхан сэтгэл

(Тэмцэж явсан үеийн өчиг)
Хүн надад ойлгуулж, би ч бас хүнд ойлгуулна. Бид идэрхэн наснаасаа
аваад, залуу зандан насандаа ч үлгэр дуурайлалтайгаар мөр зэрэгцэн
тэмцэж байна. Тэр маань улс төрийн албан тушаалыг сонгож, амьдрах
хэрэглүүр болгон, нэр төр олж аваад, эрх мэдэлтэй болонгуутаа
түүнийгээ буруугаар ашиглах болов. "Тэмцэл, дуурайлалын жишээ
болчихоод чи яагаад ингэж байна вэ?" гэж надад бодогдоно. Ололтоо
бататгахын зайлшгүй хэрэгцээ байна гэж тэр хариуллаа. Тэр өдөр л
миний өчиг баримт болсон юм.
1997

Хий үзэгдэл

(Орон зай, цаг хугацаанаас гадуур)
Бодит байдал, сэтгэл мэдрэлээс алс, орон зай, цаг хугацаанаас
гадуур, би дахин эрх мэдэлтэй боллоо...
1997

Хүндэт хүн

... Хүндэт хүний гэрт үхэл ирлээ.

Түүний амьдралын хэв маягийг үзээд анхандаа өршөөв. Гэвч тэрээр өөрийг нь дуудсан хэвээр байсан учир үхэл эцэстээ түүний хүслийг гүйцэлдүүлэв. Хүндэт хүн өөрөөс нь өмнө амьдарч байсан хийгээд хожим амьдрах хүмүүсийн нэг адил сансрын харилцан үйлчлэлээр дамжин байгаль ертөнцтэй уусан нийлж үнэний нэгээхэн хэсэг болж хувирна. Хүндэт хүн тэр үнэний төлөө, түүнийг ойлгохын төлөө их зүйл хийсэн билээ.

Хүндэт хүнийг эцсийн замд нь үдэхийн тулд хамаатан садан, хүмүүс өнцөг булан бүрээс цугларна. Хэн нэг нь түүний гэр дэх хүжийн тансаг үнэрийг мэдэрч, хүндэт хүнийг хутагт байжээ гэв. Зарим нь түүний гэрийг тойрсон гэрлийг олж хараад, хүндэт хүнийг шинэ зөнч хэмээн тунхаглажээ.

Тэгэхэд нь хүндэт хүний ууган хүүгийн ууган хүү нь өвөөгийнхөө сүүлчийн хүслийг агуулсан захиаг задалж, чанга дуугаар уншив.

"Миний сүүлчийн хүсэл миний амьдралд шигтгэгдсэн болно. Уншаад үлгэрлэл ав. Та нараас илүү нэгээхэн ч хүн үгүйг санаж авцгаа. Нөгөөтэйгүүр та бүхний хэн нь ч бусад хүмүүсээс илүү гарахгүй.

Миний хувьд гэвэл би ердийн л нэг хүн, харин эрх чөлөөг олж, сүнсээрээ уусан нийлсэн анхны хүн байж магадгүй. Миний хүсэл бол сүүлийг нь мушгихгүй байх. Учир нь би жинхэнэ утгаараа уусан нийлсэн хүмүүсээс анхных нь ч биш, сүүлчийнх нь ч биш.

Миний таалал төгссөн өдөр үнэнтэй нийлсэн, сансрын чөлөөлөлтийн өдөр болтугай. Миний шарилын хувьд гэвэл гэрт минь байрлаг. Шарил дээр минь, "Энд ногоон хөндийн хүн нойрсож буй" гэсэн бичээстэй оршуулгын ердийн чулуу байг. Миний гэрийн үүд үргэлжийн мөнхөд нээлттэй байг. Түүнийг хэрхэхээ гагцхүү цаг хугацааны эвдрэл, байгал дэлхийн ааш авир мэдэг.

Хайрт та нар минь миний өмнөөс баярлацгаа, учир нь энэ газар хичнээн том байсан ч түүний ахуй нь илүү том билээ. Цаг хугацаа хичнээн их урсахаас үл хамааран үл ахуй нь бүр ч том байх болно. Улмаар мэдрэхүй хичнээн чухал байсан ч түүний үл ахуй нь бүр илүү хүчирхэг, бодит байдлын хэмжүүр ямар байхаас үл хамааран түүний үл ахуй нь бүр илүү хязгааргүй байх болно".

1996оны5-рсар

Нийлсэн Хүмүүсээс Түүвэрлэн Хуулсан Нь

Эрэлч

Хогийн сав хэрхэн ухаж байгааг нь оройн цагаар харна. Дараа нь түүнийг зэмлэж, гашуун хувь тавиланд нь даатгаж орхино...

Дараа нь ядуу эр ирж буйг ажиглаж эхэлнэ. Эхлээд орой бүр, өглөө бүр, эцэст нь өдрийн аль ч цагт харж болно. Энэ бэрх хэв маягт хүн дасдаг, тиймээс үүнийг үл тэвчихийн оронд аанай л анхны удаа мэт эл ажлаа шаргуу хийгээд сэтгэл гарган хийдэг. Удаан хугацааны турш байдал хэвээрээ байв. Харин бид сүүлийн удаа тааралдаад харц тулгарахад би ичсэндээ газар доор орсон нэгэн байв.

1999

Уусан нийлсэн нь

Нэхэмжлэгч тангараг өргөн мэдүүлэг өгсөн энэ цагт өмгөөлөгчид хийх ёстой ажлаа хийж, эл мөчийг болтол дуугүй байсан Шүүгч-Бурхан тогтоолоо унших боллоо. Түүний ам бүүдгэр гэрэл цацруулж буй нь нэгэн зэрэг шорон гяндан, эрх чөлөөний тайтгарал байсан юм.

Нам гүн байдал намайг Шүүгч-Бурхан руу ширтэж, хэрхэн тогтоол уншиж байгааг нь сонсоход хүргэв. Түүнийг нүдээ анин, гараа хөдөлгөлгүй харахын тулд би түүнд ойртож очлоо. Ямар нэгэн хиймэл, ойлгогч шил намайг тогтоол уншиж буй Шүүгч-Бурханы өмнө нээв. Тэрхүү тогтоол нь хүний ухамсар дээр тодорхой хэмжээгээр тулгуурласан бөгөөд *буруугүй* гэх түлхүүр үгтэй. Тэр мөчид би ганцаараа байгаа, зөрчлүүд арилж, махбодууд уусан нийлж байгааг ойлголоо. Ингээд би зөнчдийн дунд ч, нүгэлтнүүдийн дунд ч байна. Бид бүгд ижил хувь тавилантай учир би тэдэнтэй, мөн тэдэн рүү, Шүүгч-Бурхантай, мөн Шүүгч-Бурхан руу уусан нийлнэ. Ухамсар бол мөн чанартаа хүний тэнцвэрийн хийгээд бусдын санасныг өөрчлөх хүслээ үл илэрхийлэхийн баталгаа билээ. Ингээд би энд хүч чадал бүхий байна. Би цаг ямагт, ахуйдаа ч тэр, үл ахуйдаа ч тэр эл хүч чадлын нэг хэсэг байсан. Тэрхүү ахуй, үл ахуйтай би хэзээ ч хагацаж байгаагүй болно.

Ингээд би энд байна. Хүч чадал, ахуй, үл ахуйн адилхан нэг хэсэг.

Учир нь хүнийг үхсэнийхээ дараа хэсэгхэн болж хувирахад юу ч саад хийж чадахгүй.

1998

Одож буй

Газар дээр, урьд амьдралдаа миний аж төрж байсан газар дээр эргэн дурсахуйгаар дүүрэн аялал хийснийхээ дараа би хувь заяаг шийдвэрлэгч шинэ аялалд гарлаа.

Аялал дууссан ч би газар дээрх дурсамжаа байнга эргэж санана. Ямар нэг хязгаарлалтгүйгээр би цаг хугацаа, орон зайн дунд хөвнө.

Би үнэмлэхүй ухамсартайдаа, түгээмэл үнэнийг мэдэрч байхдаа аливааг сэргээх, дааж дийлэх арга зам, мөн Хүнийг цаг ямагт давж гарах зүйлийг эрэлхийлэн дэмийрнэ. Би Хүнтэй, Түүний өдөр тутмын амьдрал, Түүний ирээдүй, энх мэнд байдал, Эрх чөлөөтэй холбоотой элдэв төрлийн түгшүүрээр оюун санаагаа зовооно.

Учир нь хэрэв Хүн үгүй бол амьдрал, үхэл мэтийн ойлголт ямар утга санааг агуулах байсан бол? Танин мэдэхүй, үнэн хэмээх хоёр нүүртэй Бүхнийг чадах хүч нь ямаршуухан зүйл байх байсан бол? Тэгвэл энэ тохиолдолд газар дээрх Хүний аз жаргал яагаад ийм хүрэхийн аргагүй байдаг юм бол? гэж асуумаар байна.

Тэнгэр дээрх хүний амьдралд би итгэдэг. Учир нь би өөрөө тэнд байна. Гэхдээ газар дээрх амьдралын тухай би юу хэлж чадах вэ? Түүний нөхцөл байдлыг сайжруулж болох уу?

Би өөрийн байгаа энэ газраас үүнийг хийж чадах уу?

Өлсгөлөн, шунал, сахил хүртэгсэд хийгээд бодомжгүй хүмүүс, соён гэгээрсэн хийгээд харанхуй бүдүүлэг этгээдүүдийн мөрөөдлийг гагцхүү үхэл л төгсгөдөг.

Хожим гагцхүү үхлийн ачаар л хүн бүрийн хооронд тэгш эрх тогтдог.

Миний санаа зовниж буй зүйл бол яг үнэн хэрэг дээрээ Хүн юм. Гэсэн хэдий ч би Түүнтэй, Дэлхий ертөнцтэй цаг хугацаа, орон зайнаас гадна, амьдрал хийгээд үхэлд бүрэн дүүрэн уусан нийлээгүй. Тэгвэл би яагаад шанална вэ?

Би өөрийгөө илэрхийлэх бичгийн болон өөр аливаа хэлбэрээс татгалзаад одож буйгаа та бүхэнд хэлж байна. Хазаарласан, хязгаарласан хамаагүй аливаа эргэцүүллээс чөлөөлөгдөн явж буйгаа би хэлж байна. Аливаа шохоорхлоос, тэдгээрийн дотор дарлалаас

ангижрах мөрөөдөл, үнэмлэхүй танин мэдэхүй, түгээмэл үнэнээс чөлөөлөгдөн би холдож байна. Хорвоо ертөнцийн Бурханаас Хүн чөлөөлөгдөж, одов. Эцэстээ Хорвоо ертөнцийн Бурхан өөрийн ээлжинд Хүнээс чөлөөлөгдөж, одов.

Би ч бас чөлөөлөгдөв. Хүн чөлөөлөгдөв, бас Хорвоо ертөнцийн Бурхан чөлөөлөгдөв.

1999

Мөрөөдөгчөөс түүвэрлэн хуулсан нь

Сүүлчийн хүн

Насныхаа намарт, нухацтай эргэцүүлэн бодсоны эцэст мөрөөдөгч дараах дүгнэлтэнд хүрэв:

Бурхан хүмүүсийн сэтгэлд төрдөг, дараа нь өсдөг, тэгээд өтөлдөг. Түүнийг өөрийнхөөрөө хүлээн авдаг хүмүүс Бурхан Хүнийг зөвхөн зугаацаж цэнгүүлэхийн тулд бүтээсэн гэдэгт итгэдэг бөгөөд тийм ч учир энэхүү солиоролд өөрсдөө автдаг. Гэхдээ үүнээс эмээдэг хүмүүс ч өөрсдийгөө Түүнд дэндүү ихээр зориулж, аж төрөхөө ч умартдаг тул ижил төстэй үйлдэл хийж буй юм. Цаг хугацаа, орон зайд өтөлж, ахуй, үл ахуйд төөрөх өөрийн төрхийн тухай төсөөлөлтэй Хүн Бурхны эрэлд гарахдаа үхэл бүхнийг нэгэн зэрэг устгаж, түүнийг өөрийнх нь эрж хайж байсан, эсвэл эрж хайж эхлээ ч үгүй байсан тэр зүйлтэй бүрэн уусгаж нийлүүлдгийг мартдаг.

Үхлээс эмээдэг, гэхдээ ахуйг ухамсарладаг Хүн бүр ч илүү айдаг. Тухайлбал тэрээр байгаль, дэлхийн бусад махбодийн нэг адил чөлөөлөгдсөн оршихуйд шилжиж, нөгөө ертөнцийн амьдралд амар хялбар уусан нийлж чаддаггүй.

Түүнээс гадна тэрээр амьдралын дараах амьдралын тухай мөрөөдөж байхдаа үүнийг өөрийн мэдэх тэр амьдралтай л адилтгаж төсөөлөх бөгөөд түүнийг мөнх байгаасай гэж ихэд найддаг.

Тэгвэл энэ нь гэнэн биш гэж үү? Хүн өөрөө Бурхан болж хувирахгүй гэж үү? Шүтэх зүйл хайсан Хүн өөрийгөө ойр дотны хүмүүстэйгээ

эсрэгцүүлэн бодож, тэднээс зай барьдаг. Ийм тохиолдолд хүн төрөлхтөн өөрийн агуу үнэт зүйлийн хамтаар өөртөө хэт итгэх тийм байдалд дөхөж очихгүй гэж үү? Шүтлэгийн хувьд гэвэл үнэн хэрэгтээ энэ нь найдвартай бус төгсгөлд хүрэх хамгийн амар дөт зам мөн. Харин хүн төрөлхтний тусын тулд ажиллах хүсэл нь илүү найдвартай арга юм.

Өчигдрийн өдрийг хүртэл Хүн байгалийг үнэлж байсан гэхээсээ түүний дунд тэсч амьдарч байсан. Өнөөдөр тэрээр байгалийг ашиглаж, ёсон бусаар хэрэглэж байна. Улиран хувьсах явц удаан байгаа тулдаа л Хүн түүнийг хэвээр хадгалж чадсан. Дэлхий ертөнц улам бүр хурдацтай хөгжиж буй нөхцөлд Хүн өнөөдрөөс эхлэн цаашид байгалийг хадгалж үлдэж чадах уу? Бодит хэрэг дээр хүн төрөлхтөнд ирээдүй байхгүй гэсэн дүгнэлтэнд мөрөөдөгч эцсийн дүндээ хүрнэ. Учир нь хомхой ховдог сэтгэлийг тойрсон хүн төрөлхтөн арьсний өнгө, хэл, газар нутаг, шашин шүтлэг, ягшмал номлолоос хамааран байнга таран бутарч байхад хүнлэг сэтгэл ор тас мартагджээ.

2000

Сүлд дууллаас

9

Би - шинэ төрсөн, залуу, хөгшин ч мөнхийн

Би - ургацын эх эцэг

Би - амьгүй соёл, ургац

Би - энэрэнгүй, уур хилэн, өнчрөлийн бэлгэ тэмдэг

Би - аз жаргалгүй, үзэн ядалт дарлал, хайр

Би - итгэл, хүлээлт, хувь заяа, аз жаргал

Би - бодол, үнэн, итгэл мөрөөдөл

Би - харваж буй од

Би - амьдрал, үхэл, оршин тогтнохуй, үл оршин тогтнохуй

Би - Бурхан, үхэлгүй

Эд - бүгд юу ч биш

Би бол хүн.

Би хариуцлагатайгаар оршин тогтнож байна

Чи ч бас оршиж байна

Бид бас бүгдээрээ оршин байна

Эв нэгдэл биднийг холбож
Сайн ч муу ч бидний үүрэг
Хариуцлага хүлээж байна.
2000

Альфа - омега хийсэн түүвэр

Илгээмжээс

Хайран цагийг хий дэмий үрэх Уулзалт үнсэлт хоёрт итгэж
Хоосон зүйлд төөрөгдөх,
Мөрөөдөл болошгүй зүйлд автана Хайран цагийг хоосон үрэх;
Агаар, тэнгис, газар дээр
Цагийг дэмий үрэх;
Үргэлж явж байхыг (аялж байхыг) хүсье.
Бурхан минь! Дэмий хоосон өнгөрсөн хугацааг (юу ч хийж
бүтээгээгүй) эргэн санахад ямар их харамсалтай юм.
Амьдралын тухай
Амьдралын аян замыг эргэн харахад (санахад)
Хариултаас илүү асуулт нь илүү их юм гэдгийг (гэдэг гүн
ойлголт) Ухааран ойлгохыг би их хичээсэн юм.
2002

Сүүлчийн дусал нулимс Одон салж явахад дусалсан нулимс
маань
Бүлээн, гунигаар дүүрэн байх болов уу?
Эсвэл эрх чөлөө олгож буй жаргалтай уянгалаг байх болов уу?
Аянга мэт сүүлчийн дусал нулимс минь
Алсын замд намайг одохыг түлхэж орхив уу?
Зүйрлэшгүй баяртайгаар эрх чөлөөний дуу аялан би замд гарна.
Энэ дууг би хэзээ ч бичиж байгаагүй ч
Түүнийг би анх удаа амь тавчдан дуулж явна.
Энэ дууг би яван явталаа дуулж дуусгана.
Энэ дууг би өөрөө өөртөө үргэлж дуулах болно.
2002

*Сонсогчоос***Каин**

Каин, чи юу хийчих ваа, юу болов оо, хүн чамайг юу болгочихов? Чи ахаа алчихаа юу, эсвэл хүний төсөөлж буйгаар чамайг түүний үхэлд буруутгаа юу? Чиний нөр их хөдөлмөр, хайр дурлал зэргийг үгүйсгэж өргөл барц өгсөн бурханд Авель үнэхээр их таалагдсан уу? Оюуны, бие бялдрын хувьд сул дорой өчүүхэн амьтан чамд би хөнгөлөлт (амар амьдрах) зүйлсийг өгөхөд бэлэн байна. Хэрэв Авель эзний (бурхны) шуналаас болж чамайг алагчлан үзэх шинжээс үл хамааран чамайг алсан бол би түүнийг хэзээ ч үл уучлах болно.

2002

Харамсал

Түүнийг тэндээс цовдолон дүүжлүүлсэн байхыг олов. Түүнийг бусдын төлөө амиа золиослосон гэдгийг дахин олж мэдэв.

Хэдийгээр бид хоёр хамтран амьдраад удаж байгаа боловч бид хоёрын хооронд холбоо (барих хэрэгсэл) байхгүй (үгүй) байна.

2002

Тээрэм

Сервантес! Би чамайг аль хэдийнээс хойш хайж байгаа ч үргэлж Россинанте-г унасан Дон Кихот болон түүний тээрэм хүрэх замд түүний үнэнч хамтран зүтгэгч үргэлж араас нь дагаж явдаг илжиг унасан Санчо хоёртой тааралдах юм. Эрхэм Мигель, чи өөрийн оюун ухаан болон хүмүүсийн сэтгэхүйд Дон Кихотыг дүрслэн үлдээж чадав уу? Аз болж чиний тэр баатрын дүрийг би тогтоож авах хэрэгцээгүй юм, учир нь тэр чинь чи өөрөө шүү дээ. Тийм учраас миний аян замд (ямар нэгэн сонирхолтой буй зүйл тохиолдоно) Дон Кихот Санчо хоёрт тохиолдсон сонирхолтой адал явдал тохиолдоход сайн бэлдэж өг.

2002

Даг

Хаммаршельд! Чи чинь бараг НҮБ-ын хоёр дахь ерөнхий нарийн бичгийн дарга юм байна шүү дээ. Учир нь чи Швед гаралтай хүн юм байна шүү дээ. Түүнээс гадна танайд бараг дайны (болоогүй удсан) мартаад их удсан учир чамд боломжийн хирээр даян дэлхийд энх тайван тогтоох элч

болох бүрэн боломж байна. Өөрийн үүргийн дагуу чи тус байгууллагын автономит байх асуудлыг ашигтайгаар бүрэн шийдвэрлэж чадна. Ганц талыг барьсан дундыг баримтлагч бэлгэ тэмдэг төдий болсон уг байгууллагыг харахад ямар их харамсал төрдгийг ойлгоно биз.

2002

Хөвгүүдээ гэж...

Америкийн Нэгдсэн Улсын эрх чөлөөний бэлгэ тэмдэг болсон Жорж Вашингтон гуай, эд нэр Таны хөвгүүд шүү. Таны хөвгүүд гэдэг нь хүмүүн төрөлхтний илүү аз жаргалтай амьдралын төлөө хүндэтгэл хүлээж бас үнэнч ажиллаж явсан хүмүүний хөвгүүд шүү. Та насан хутаг олоод хоёр зуун өнгөрч байна, эднийгээ эргээд нэг хар даа. Эд нар ус хийгээд амьдралын эрэлд "Ангараг" хүртэлх орон зайг хэрхэн эзэмших туршлага хуримтлуулсан хэдий ч, энэ дэлхий дээр бохирдож бузартсан усыг үлдээн орхисны уршгаар эрх дархгүй сая сая хүмүүн ундаасан цангаж үхлийн ирмэгт ирээд байгааг эргээд нэг харна уу! Ер нь ийм хөвгүүдтэй болох юмсан гэж Вашингтон, Та бодож явсан уу?

2002

Дурдатгалаас хийсэн түүврүүд

Оршилоос,

Балчирхан хүү минь, өвөө чинь захиргааны талын ажил, ихэнхдээ нягтлан бодохын ажилтай байснаас болоод чамайг бичих эрдэмд сургаагүй нь энэ хэдэн тооноос л болж хүүгээ балласан даа гэж надад байнга ярьдаг байж билээ. Харин би уншсан зүйлийн минь ихэнх нь зохиол гэж хэлэмгүй буруу зөрүү бичсэн юмыг ашиглаж ирсэн болохоор энэ хэдэн үсэг л намайг баллаж орхисон доо гэж хэлмээр байгаа юм. Тэгсэн хэдий ч энэ хэдэн үсэг л надад ашиг тустай байж, их амжилтанд хүргэсэн төдийгүй, үүгээр чинь би хоолоо олж идэж байна шүү дээ. Гэхдээ утга зохиолын сан хөмрөг болох бичиж туурвих ажилд энэ биеэ зориулахад минь саад болсоор л байна. Чи, хэн болчихоод дарлалаас ангижрах... энэ тэр гээд байна, хүн л юм бол ямар байсан нь хамаагүй удам судраараа

бахархах ёстой; сайн юмы нь өвлөн баяжуулж, алдаа эндэгдэлийг нь залруулахаар зорих ёстой биш үү. Чиний удам судар энэ газар дэлхий гээч нь зөнч мэргэд, Христийн сургаал дэлгэрүүлэгчид хийгээд хутагт хувилгаадад харьяалагдаж байсан үеэр хугацаалан үзэх настай шүү. Би бүхнийг мэдэх зөнч мэргэд, Христийн сургаал дэлгэрүүлэгчид хийгээд хутагт хувилгаадын тухай төдийгүй, цаг үеийнхээ зөвшөөрөгдсөн үнэт зүйлстэй тохирох насыг элээсэн хүн бүрийн танин мэдэхүй, соёлд санаа зовниж явдаг мөн дээр дурдсан үеийнхний талаар ярьж байна. Хүү минь, чиний өвөг дээдэс дэлхийн зүрх хэмээх Дорно зүгт байдаг юм шүү. Цорын ганц Бурхан тэнгэр Ээлийг нээсэн Арамейчууд чиний овог буюу Ээлийн зарц Нааман гэдгийг хайрласан билээ. Арамейн цэргийн жанжин Сири хүмүүн Нааманыг өөрийг нь шинэ эриний өмнөх есдүгээр зууны үед Иордан голын эрэгт долоон удаагийн тулаанд ороод явахад нь зөнч мэргэн эмэгтэй Элиша түүний уяман өвчнийг эдгэрүүлж өгч байв. Мөн арамей хэл Христийн өөрийнх нь хэл байсан юм шүү. Бас чи чинь удаан хугацаанд байж чадахгүй болж, өөр нэг соёл иргэншилд зайгаа тавьж өгч, ул мөргүй болсон эртний үсэг бичгийг зохиосон Финик кананитийн хүү шүү. Түүнчлэн чи чинь угтаа үнэний төлөө үхэн хатан тэмцэж явсан боловч, өнөөдөр тэр нь бүрмөсөн мартагдаж, хойшид сэргэх найдваргүй болсон арабуудын хүү шүү. Чи болбоос амжилт ялалт нь олзонд улайран шунах явдлаас болоод үндэстний хэмжээнд бус бөлөг хувь хүмүүсийн дунд үлгэр жишээ болсон Ливан улсын хүү шүү. Бас эцэст нь хэлэхэд чи бол хэдийгээр тусгаар салангид ч гэсэн түүнд өнөөдрийг хүртэл сүсэгтнүүд Бурхан тэнгэрийг сүлд дуулал болгон алдаршуулан дуулж байгаа өнө эртнээс үүсэлтэй Дорнын сүмд загалмайлуулсан хүн шүү. Хүү минь энэ бүгдээрээ бахархаж яваарай! Үүний зэрэгцээ чи бол цаг үеийн хийгээд бүх хүмүүн төрөлхтний хүү нь юм шүү гэдгийгээ эгнэгт санаж яваарай. Бас гэрийнхний чинь хэн, хэн нэг нь ч бусдыг хэзээ ч дарлаж яваагүй айлын хүүхэд байна гэдгээ бүү мартаарай. Эсвэл энэ үгийн хамгийн өргөн, захын утга болох бусдыг дарлан мөлжиж яваагүй тийм хүн л хүний нүүрийг бүрэн харж амьдарч чаддаг юм шүү. Шудрага бусаар шүүгдэж шорон гянданд хоригдсон байлаа ч гэсэн хүмүүнлиг чанараа шоронгийн гадаа байлга, эс тэгвээс чамд маш хэцүү байх болно.

1998

الثقافة بالمجان

Ath-Thaqafa bil Majjan

Série littéraire gratuite établie et dirigée depuis 1991 par
Free of charge literary series established and directed since 1991 by
Serie literaria gratuita establecida y dirigida desde 1991 por
Naji Naaman

najinaaman
an-najiyyat

AN-NAJIYYAT

النَّجِيَّات

© Tous droits réservés – All rights reserved – Todos los derechos reservados – الحقوق محفوظة
Maison Naaman pour la Culture & www.najinaaman.org